



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/135

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.9, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.12.3 дэх заалт, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох байгууллага, аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эмийн сангийн стандарт MNS5260:2015, Сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2013, Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл, үйл ажиллагаа MNS5081:2013, өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлэг, эмийн сангийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан болон шинээр олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ ЭРДЭНЭ

482010385

Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 1/35 дугаар захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

| № | Үүсгэн байгуулагчийн нэр | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар | Тусгай зөвшөөрлийн хугацаа | Хугацаа |
|----|--|--|---|--|----------------------------|--------------------------|
| 1 | БГБХ-нөхөрлөл | Боржигон мандал өрхийн эрүүл мэндийн төв | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ | ЭУ-15/10/999 | 5 жил | 2020-04-25 2025-04-25 |
| 2 | БГБХ-нөхөрлөл | Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төв | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ | ЭУ-15/10/1000 | 5 жил | 2020-04-25 2025-04-25 |
| 3 | Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар | Өндөршил Эрүүл мэндийн төв | Эмнэлэг, сувилал бүх төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа | ЭУ-14/10/976 | 5 жил | 2020-04-25 2025-04-25 |
| 4 | Орон нутгийн өмчит ААТҮГ | Сайнцагаан сумын эм эргэлтийн сан | 2-р зэрэглэлийн эмийн сан | ЭСХ-15/10/1006 | 1 жил | 2020-04-25 2021-04-25 |
| 5 | Орон нутгийн өмчит ААТҮГ | Гурвансайхан сумын эм эргэлтийн сан | 2-р зэрэглэлийн эмийн сан | ЭСХ-14/02/973 | 3 жил | 2020-04-25 2023-04-25 |
| 6 | Орон нутгийн өмчит ААТҮГ | Сайхан-Овоо сумын эм эргэлтийн сан | 2-р зэрэглэлийн эмийн сан | ЭСХ-15/10/1004 | 3 жил | 2020-04-25 2023-04-25 |
| 7 | Орон нутгийн өмчит ААТҮГ | Дэрэн сумын эм эргэлтийн сан | 2-р зэрэглэлийн эмийн сан | ЭСХ-15/10/1008 | 3 жил | 2020-04-25 2023-04-25 |
| 8 | Орон нутгийн өмчит ААТҮГ | Дэлгэрцогт сумын эм эргэлтийн сан | 2-р зэрэглэлийн эмийн сан | ЭСХ-15/10/1002 | 3 жил | 2020-04-25 2023-04-25 |
| 9 | "Өөш тур" ХХК | "Өөш манхан" сувилал | Сувилахуйн тусламж үйлчилгээ | ЭХ-15/10/1024 | 3 жил | 2020-06-12 2023-06-12 |
| 10 | "Цог" ХХК | "Цог" эмийн сан | 2-р зэрэглэлийн эмийн сан | ЭСХ-15/10/1023 | 2 жил | 2020-06-12 2022-06-12 |
| 11 | "Болорбадмаараг" ХХК | "Онч" эмийн сан | 1-р зэрэглэлийн эмийн сан | ЭСХ-20/10/1043 | 3 жил | 2020-05-08 2023-05-08 |